





ТРАНСКАПИТАЛ
ББСБ



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН-2024



Агуулга

1

БҮЛЭГ

1. БИДНИЙ ТУХАЙ	4
Эрхэм зорилго	6
Үнэт зүйл.....	6
Тогтвортой хөгжлийн зорилт	6
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.....	7
Түүхэн замнал.....	8
Тогтвортой хөгжлийн амжилтууд.....	10

2

БҮЛЭГ

2. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	12
Транскапиталын тогтвортой хөгжлийн бодлого	13
Байгаль орчин, нийгэм засаглалын эрсдэлийн үнэлгээ	14
А. А. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	15
Дээхий.....	15
Эрчим хүч.....	16
Ус.....	17
Хог хаягдал, цаасны хэрэглээ	18
Мод тарих аян	19
Уур амьсгалын өөрчлөлт	20
Ногоон зээлийн бүтээгдэхүүн	21
Монгол гэрийн халаалт, дулаалга, агаар сэлгэлтийн ЧИП багц.....	22
Байшин дулаалгын Дулаан Шийдэл 2 төсөл.....	23

В.	В. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ	25
	Тогтвортой нийгмийн хариуцлага.....	25
	Дэлхийн мөнгөний 7 хоног	25
	Хандив, тусламж	26
	Тогтвортой хөдөлмөр эрхлэлт.....	27
	Ажилтнуудын сургалт, хөгжил, олон нийтийн үйл ажиллагаа.....	28
	Жендерийн эрх тэгш байдал.....	31
	Эрх тэгш, хүртээмжтэй байдал	32
	Хөдөлмөрийн аюулгүй байдал.....	32

С.	С. ШУДАРГА ЗАСАГЛАЛ	34
	Тогтвортой засаглал.....	34
	ТУЗ-ын үйл ажиллагаа, хороод.....	36
	Эрсдэлийн удирдлага.....	37
	Комплаенс.....	37
	Авлига, ёс зүй.....	38
	Харилцагчийн эрхийг хамгаалах.....	39

3

БҮЛЭГ

3. ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ БОЛОН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ	41
Санхүүгийн хүртээмж.....	42
Тогтвортой хөгжлийг дэмжсэн хамтын ажиллагаа	46

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	47
--	----






1 БҮЛЭГ

БИДНИЙ ТУХАЙ

Транскапитал ББСБ нь 2001 оноос хойш бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж, зээл олголт, санхүүгийн зөвлөгөө, сургалт, семинар зэрэг цогц дэмжлэгийг тогтмол үзүүлсээр ирсэн билээ. Өдгөө Монгол улсын хэмжээнд 38 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



53317

шинээр нэмэгдсэн
ажлын байр



20 зээлийн
бүтээгдэхүүн,
үйлчилгээ



38
салбар



29999
дэмжиж буй
ажлын байр



ЭРХЭМ ЗОРИЛГО



ҮНЭТ ЗҮЙЛ

Бид санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэхдээ мэргэжлийн төвшинд бүтээлч ба найдвартай ажиллагаагаар харилцагчид, санхүүгийн хэрэгцээтэй үйлчлүүлэгчидийг хамруулж, хөрөнгийг өсгөх, баялаг хуримтлуулах, хөрөнгө оруулагчид, хувь нийлүүлэгчидийнхээ хөрөнгийг сайжруулах замаар харилцагчидийн үйл ажиллагааг дэмжих зорилготой.

- Хэзээд бүтээлч, шинийг сэтгэгч санхүүгийн шийдвэр гаргагч байх,
- Үйл ажиллагааныхаа бүхий л төвшинд байгаль орчин, нийгэмд хариуцлагатай шударга ёс суртахуунтай үзэл бодлыг баримтлах,
- Ажиллагсдынхаа дуу хоолойг дээдэлсэн нээлттэй бодлого баримталдаг чадварлаг тэргүүний баг байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

Манай байгууллага нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн дараах зорилгуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Ядуурлыг устгах
2. Жендерийн тэгш байдлыг хангах,
3. Зохистой хөдөлмөр болон эдийн засгийн өсөлтийг дэмжих,
4. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг багасгах. Эдгээр зорилгоор дамжуулан тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Юуны өмнө та бидний хамтын ажиллагаа амжилт бүтээлээр дүүрэн, бодит үр дүнд хүрсэн жилийг хамтдаа үдэж буйдаа таатай байна. Бид 2024 онд стратегийн бодлогоо амжилттай хэрэгжүүлж, тогтвортой санхүүгийн бодит үнэ цэнийг харилцагчдадаа хүргэхэд чиглэсэн олон чухал ажлыг хэрэгжүүллээ.

Нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор өрхийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн бичил болон жижиг бизнесийн санхүүжилтийг онцгойлон дэмжиж, тэр дундаа жендерийн тэгш байдлыг хангах бодлогын хүрээнд эмэгтэй болон залуу бизнес эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажиллалаа.

Эдгээр бодлогын хүрээнд нийт зээлийн багцын 65%-ийг бичил, жижиг бизнес эрхлэгчдэд олгосон бөгөөд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна 3,400 гаруй харилцагчийг бизнесийн өсөлтөд чиглэсэн сургалт, сүлжээ байгуулах уулзалт, чадавх бэхжүүлэх семинаруудад хамруулсан юм.

Бид харилцагчдынхаа бизнесийг дэмжихийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, хариуцлагатай санхүүжилтийг нэвтрүүлэхэд онцгой анхаарч буй.

Мөн агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчийг хэмнэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилготой

санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын байгууллага, төрийн бус байгууллагууд, итгэлт түншүүдтэйгээ хамтран амжилттайгаар хүргэж байна. Тухайлбал, 2024 онд бид Water.org олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, баталгаат ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн онцлог жил байлаа.

Үүний үр дүнд ногоон зээлийн хэмжээ нийт зээлийн багцын 6%-д, гэр хорооллын өрхүүдийн орон байрны засвар, шинэчлэлийн зээл 12%-д хүрч, иргэдийн амьдрах нөхцөл, эрчим хүчний хэрэглээ, ундны ус болон ариун цэврийн хүртээмжийг сайжруулахад бодит хувь нэмэр оруулж чадлаа.

Эрхэм та бүхний бидэнд итгэж, хамтдаа хөгжих чин эрмэлзэл бидний урагшлах хүч, амжилтын эх булаг юм. Цаашид илүү хүртээмжтэй, тогтвортой хөгжлийг дэмжсэн санхүүгийн үйлчилгээг Монгол Улсын өнцөг булан бүрт хүргэхийн төлөө тууштай ажиллах болно.

Бидэнтэй мөр зэрэгцэн ажилладаг Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг болон бүх түншүүддээ чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн:

З.Алтанзул



ТҮҮХЭН ЗАМНАЛ



Монголбанкаас ББСБ-ын тусгай зөвшөөрөл авч, 3 ажилтантай, 50 сая төгрөгийн дүрмийн сантайгаар бичил зээлийн үйл ажиллагаагаа эхлүүлэв.

2001

2004

Улаанбаатар хотын алслагдсан дүүргүүдэд 5 салбар нээж, үйлчилгээг илүү хүртээмжтэй болгож эхлэв.

Олон улсын бичил санхүүгийн MIX Market платформд байгууллагын мэдээллийг нээлттэйгээр байршуулж, ил тод байдал, олон улсын хамтын ажиллагааны үндсийг тавив. 2007 он Олон улсын үнэлгээний байгууллага MicroFinanza-гаас "В" үнэлгээ авсан Монголын анхны ББСБ болов.

2006

2010

Харилцагчдад илүү ойртохын тулд 11 дэх салбараа амжилттай нээж, олон улсын харилцаагаа өргөжүүлэв.

МҮХАҮТ-аас ТОП 100 аж ахуйн нэгж-ээр зургаа дахь удаагаа шалгарч, амжилтаа бататгав.

2011

2012

Орон нутгийн анхны салбараа Орхон аймагт амжилттай нээлээ.

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-тай стратегийн хамтын ажиллагаагаа эхлүүлэв.

2013

2014

Гадаадын хөрөнгө оруулалтыг татсан амжилтаараа МББСБХ-ны "Шилдэг хөрөнгө оруулагч ББСБ" шагналыг хүртэв.

2017

20 салбартай болж, үйлчилгээгээ харилцагчдадаа илүү ойртуулаа.



2020

- Global Banking and Finance Review сэтгүүлээс The Next 100 Global Company шагнал хүртэв.
- Дэлхийн Банкны Олон Улсын Санхүүгийн Корпорацитай хамтран ажилласан Монголын анхны ББСБ болов.
- Олон улсын байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын стандартыг 2020 оноос бүрэн хэрэгжүүлж эхэллээ.



2021

- Монгол Улсын эдийн засгийн чадавхийг дэмжих, жижиг дунд бизнесийг бодитоор хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж, МҮХАҮТ-аас "Бизнесийн эрхмэт оролцогч" шагнал хүртэв.
- ЕСБХБ-тай хамтран хэрэгжүүлсэн "Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд" хөтөлбөрийн анхны санхүүгийн байгууллага болов.



2022

- "Онцлох ToC санхүүгийн 2022"-оор шалгарав.
- Сэлэнгэ аймагт 36 дахь салбараа нээв.
- Байгаль орчин, нийгэмд ээлтэй тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх чиглэлээр 10 хувийн ногоон зээлийн багц бүхий хамтын ажиллагааг албан ёсоор эхлүүлэв.



2023

- ЕСБХБ-ны "Төв Азийн Залуу Бизнес Эрхлэгчдийг Дэмжих Хөтөлбөр"-ийн нээлтийг хийв.
- "Тогтвортой хөгжил 2024" шагнал гардуулах ёслолоос "Жендэр ба эдийн засгийн оролцоо" ангилалд Алтан шагнал хүртэв.



2024

- Монголын ББСБ-уудын холбооноос "Шилдэг Нийгмийн Хариуцлагыг хэрэгжүүлэгч байгууллага"-аар шалгарсан.
- "Шилдэг ТОС Санхүүгийн Байгууллага 2024" болон тогтвортой хөгжлийн олон улсын үнэлгээгээр дахин амжилт гаргалаа.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЖИЛТУУД



ШИЛДЭГ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Тогтвортой санхүүжилтийн холбоо (ТоС)-ноос жил бүр зохион байгуулдаг “Шилдэг нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэгч” байгууллагын шагналын эзнээр Транскапитал ББСБ 2024 онд дахин шалгарлаа.

Тус шагнал нь тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэн, нийгэмд эерэг нөлөө үзүүлж буй байгууллагуудыг үнэлж, урамшуулах зорилготой салбарын нэр хүндтэй арга хэмжээнүүд нэг юм.

Байгууллагын амжилтыг баталгаажуулахаас гадна тогтвортой санхүүжилт, нийгмийн хариуцлагын үзэл баримтлалыг олон нийтэд таниулах, бусдад үлгэр дуурайл үзүүлэх чухал ач холбогдолтой гэдгээрээ онцлогтой.



ШИЛДЭГ ТОС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Бид 2024 оны “Шилдэг ТоС Санхүүгийн Байгууллага” шагналыг хүртлээ.

Энэхүү нэр хүндтэй шагналыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон ТоС холбоо хамтран жил бүр олгодог ба Тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэн, ногоон эдийн засгийн хөгжилд манлайлан оролцож, тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй байгууллагуудыг шалгаруулдаг юм.

Манай байгууллага 2022 онд “Онцлох ТоС Байгууллага”-аар шалгарч байсан бол 2024 онд дахин нэр дэвшиж, “Шилдэг ТоС Санхүүгийн Байгууллага” шагналыг хүртсэн нь бидний тогтвортой хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгааг харуулж буй.

2024 оны амжилтаас



GOLD AWARD

Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны 33 дахь удаагийн Бизнес форумын үеэр Транскапитал ББСБ нь “Жендер ба эдийн засгийн оролцоо” ангилалд “GOLD AWARD” шагналыг хүртлээ..

Уг шагнал нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүд дундаас тогтвортой хөгжлийн зорилгыг тэргүүлэх чиглэлээ болгон хэрэгжүүлж, бодит үр дүн, эерэг нөлөөлөл үзүүлсэн түнш байгууллагуудад жил бүр олгодог юм. Шалгаруулалтын хувьд нийт 6 ангилалд явагддаг ба энэ жил олон улсын 63 төсөл нэр дэвшсэн байна.

Жендерийн тэгш байдал болон эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бидний хэрэгжүүлсэн санаачилга, гаргасан бодит үр дүнд үндэслэн энэхүү нэр хүндтэй шагналыг олгосон нь манай байгууллагын нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн зорилтуудад тууштай, үр дүнтэйгээр хандаж ирснийг олон улсын түвшинд өндрөөр үнэлсэн томоохон амжилт боллоо.





2 БҮЛЭГ

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ




ТРАНСКАПИТАЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Байгаль орчин, Нийгмийн Эрсдэлийн Удирдлагын Системийн бодлого (БОНУСБ)-ыг салбартаа анх удаа 2020 онд баталж, 2023 онд олон улсын санхүүгийн байгууллагууд болон Санхүүгийн зохицуулах хорооны зөвлөмжийн дагуу шинэчлэн баталлаа.

Уг бодлогын гол зорилго нь 2030 он гэхэд нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээг 10%-д хүргэх, байгаль орчин болон нийгмийн эрсдэлийг илрүүлж, бууруулах, удирдах үйл явцад манлайлан оролцох явдал юм.

Бид үйл ажиллагаандаа олон улсын сайн туршлага, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн зарчмуудыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын эрх зүйн баримт бичиг, олон улсын санхүүгийн байгууллагуудын гүйцэтгэлийн стандартууд, Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) болон Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) хөтөлбөрийн үндсэн зарчмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Олон Улсын Санхүүгийн Корпорацын гүйцэтгэлийн 8 стандарт





БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ




Бид 2020 онд байгууллага болон харилцагчдын үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирсан эрсдэлийг арилгах, засаж сайжруулах зорилгоор Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог анхлан бүрдүүлж, тасралтгүй хэрэгжүүлсээр байна.



2024 онд нийт олгосон зээлийн 95%-д байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) эрсдэлийн үнэлгээг хийж, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхээс татгалзлаа.

Нийт зээлийн багцын 99%-ийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, нөлөөлөл багатай зээлүүд бүрдүүлж байна.

Өндөр эрсдэлтэй, засвар сайжруулалт шаардсан зээлүүд зээлийн багцад бүртгэгдээгүй бөгөөд энэ нь манай санхүүжилтийн эрсдэлийн удирдлагын бодлогын илрэл юм.



А.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Байгаль орчны үзүүлэлтүүдийг GRI тогтвортой хөгжлийн тайландаа дараах байдлаар тусгалаа.



Эрчим хүч, ус, цаас, хог хаягдал, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгалийн нөөцийн зохистой ашиглалт, менежмент нь хувь хүн, байгууллага, улс орны түвшинд амьдралын чанарыг сайжруулах, байгаль орчны эрүүл мэндийг хамгаалахад чухал үүрэгтэй юм.

ДЭЭХИЙ

Ногоон хөгжлийн санаачилгын хүрээнд бид “ногоон оффис”-ын стандартыг хэрэгжүүлж, ажилтнууд болон тэдний хүрээлэлд экологийн ул мөрийг бууруулах зорилт тавин ажиллаж буй.

Энэхүү хүрээнд “Дээхий” нэртэй маскотыг бүтээж, байгууллагын дотоод соёлыг байгаль орчинд ээлтэй, тогтвортой амьдралын хэв маягаар төлөвшүүлэхэд чиглэсэн уриалга, зөвлөмж, мэдээллийг тасралтгүй түгээж байна.



ЭРЧИМ ХҮЧ

Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон технологид суурилсан шийдлүүдийг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох салбарын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Бид тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад онцгой анхаарч, цахилгаан эрчим хүчний хэрэглээг оновчтой, үр ашигтай зохицуулах бодлогыг тууштай хэрэгжүүлж буй.

7 СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧИЙГ
НЭВТРҮҮЛЭХ



Тодруулбал, 2024 оны байдлаар байгууллагын нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээ 205,384.22 кВт.ц байсан нь санхүүгийн байгууллагуудын дэлхийн дундажтай харьцуулахад 8.7 дахин бага үзүүлэлт юм.



Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ:

205,384.22 кВт.ц

Түүнчлэн нэгж салбарын цахилгаан хэрэглээ дунджаар 947 кВт.ц байгаа бөгөөд энэ нь 1 кВт.ц-ийг ₮265-өөр тооцоход сар бүрийн цахилгааны төлбөр дунджаар ₮251,000 болж буй. Уг үзүүлэлт нь байгууллагын зардлын оновчтой менежмент болон ногоон хэрэглээг дэмжиж байгааг илтгэнэ.



Сар бүрийн цахилгааны төлбөрийн дундаж:

251,000 төгрөг

УС

Монгол Улс нийт усны хэрэглээнийхээ 80%-ийг газрын доорх гүний усаар хангадаг ба нийт нутаг дэвсгэрийн 77% нь цөлжилт, газар доройтолд өртөж байгаагаас усны нөөцийг хамгаалах, хариуцлагатай ашиглах шаардлага улам бүр нэмэгдэж буй.

Үүнээс үүдэн бид тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд усны нөөцийг хэмнэх, бохирдлыг бууруулах, цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дотоод бодлого боловсруулан тууштай хэрэгжүүлж байна.

Байгууллагын дотоод усны хэрэглээг оновчтой, хариуцлагатай ашиглахыг уриалан, ажилтан болон харилцагчдын дунд усны хэмнэлтийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах зорилгоор сургалт, мэдээлэл, уриалга санаачилгыг тогтмол зохион байгуулсаар ирлээ.

Мөн баталгаат ундны ус болон ариун цэврийн байгууламжаар хангах зорилгынхоо хүрээнд 2024 онд Water.org олон улсын байгууллагаас техникийн туслалцаа авч, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ улам сайжруулан, дараах гол ажлуудыг амжилттай хэрэгжүүллээ. Үүнд:

6 БАТАЛГААТ УНДНЫ УС
АРИУН ЦЭВРИЙН
БАЙГУУЛАМЖААР
ХАНГАХ



Харилцагчдын ундны ус, ариун цэврийн байгууламж, жорлонгийн нөхцөл байдлыг нарийвчлан судалж, хөрсний асуудал болон ундны усны чанарыг сайжруулах чиглэлээр зээлийн санхүүжилтийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, олон нийтэд чиглэсэн уриалга, нөлөөллийн кампанит ажлуудыг амжилттай хэрэгжүүлэв.



Дотооддоо 24 сургагч багшийг бэлтгэн, 38 салбар болон төв оффисын бүх ажилтныг хамруулсан сургалт амжилттай зохион байгууллаа.




Хашаа байшин барьж, засвар хийж буй харилцагчдад зориулан зөвлөгөө өгч, өртгийн нарийвчилсан тооцоолол хийх зорилго бүхий “Rapid Assessment” аргачлалыг сайжруулан хэрэгжүүлж байна.

ХОГ ХАЯГДАЛ, ЦААСНЫ ХЭРЭГЛЭЭ

Манай байгууллагын үйл ажиллагаа оффисын орчинд төвлөрдөг тул биечлэн үүсэх хог хаягдлын хэмжээ харьцангуй бага байдаг.

2024 оны байдлаар нийт цаасны хэрэглээ ойролцоогоор



Сонирхуулахад, дэлхийн дунджаар нэг оффисын ажилтан жилд 10,000 хуудас буюу өдөрт 27 орчим хуудас цаас хэрэглэдэг ба үүний 17% орчим нь ашиглагдалгүй шууд хаягддаг аж. Энэ нь нэг ажилтан жилд дунджаар 68 кг цаас хэрэглэдэг гэсэн үзүүлэлттэй дүйж буй.



Дэлхийн дунджаар нэг
оффисын ажилтан жилд
10,000 хуудас

Харин Транскапитал ББСБ-ын хэмжээнд сар бүр дунджаар 185 боодол буюу 9,250 хуудас цаас хэрэглэж байгаа нь жилийн дүнгээр 2,200 боодол, буюу 110,000 хуудаст хүрч байна. Ингэснээр нэг ажилтанд ногдох жилийн хэрэглээ дунджаар 550 хуудас буюу 2.5 кг болж байгаа нь дэлхийн дундажтай харьцуулахад 18 дахин бага үзүүлэлт юм.



Транскапитал ББСБ-ын нийт
ажилтнууд сард **9,250**
хуудас

жилийн дүнгээр
110,000 хуудас

нэг ажилтанд ногдох жилийн
хэрэглээ **550** хуудас

ЭКОЛОГИЙН УЛ МӨР:
18 ДАХИН БАГА /цаас/



МОД ТАРИХ АЯН

Байгаль орчинд ээлтэй, тогтвортой орчныг бүрдүүлэх зорилгоор бид мод тарих, ногоон бүтээмжийг нэмэгдүүлэх, цаасны хэрэглээг багасгах аяныг тогтмол зохион байгуулсаар ирсэн билээ.

Тухайлбал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих хүрээнд нийт 8,200 мод тарьсан нь байгууллагын ногоон хөгжлийн бодлогыг бодит үйлдлээр илэрхийлсэн чухал алхмуудын нэг болж байна.



8200 + мод
тариад байна



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Бид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ногоон санхүүжилт, ногоон хөрөнгө оруулалтыг идэвхтэй дэмжиж, байгальд ээлтэй шийдлүүдийг санал болгон хэрэгжүүлж буй.

Энэхүү зорилгын хүрээнд 2024 онд “Ногоон хөгжилд өнгө нэмье” уралдааныг 38 салбар нэгжийн дунд зохион байгуулсан ба дараах үндсэн зорилтуудыг дэвшүүлсэн юм. Үүнд:

- Хог хаягдлын хэмжээг бууруулах
- Ус, цаас, эрчим хүчний хэрэглээнд хэмнэлт гаргах
- Харилцагчдад ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Ногоон эдийн засгийг дэмжих

Уралдааны үр дүнд тогтвортой хөгжлийн зарчмыг амжилттай хэрэгжүүлж, нийгмийн хариуцлагыг үлгэрлэн хэрэгжүүлсэн шилдэг салбаруудыг шалгаруулан урамшуулж, бусдадаа манлайлах сайн жишгийг тогтоолоо.

13 УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР
НӨЛӨГ БАГАСГАХ



НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Ногоон зээлийн хэмжээ нийт зээлийн багцын 6%-д, гэр хорооллын өрхүүдийн орон байрны засвар, шинэчлэлийн зээл 12%-д хүрсэн байна.

Ногоон зээлийн бүтцэд дараах төрлийн санхүүжилтүүд багтаж байгаа ба эдгээр нь байгаль орчны нөлөөллийг бууруулах, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэж байна. Үүнд:

- Карбон бага ялгаруулдаг тээврийн хэрэгсэл,
- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж,
- Баталгаат ундны ус, хөрсний бохирдлын эсрэг шийдэл,
- Ногоон барилгын санхүүжилт зэрэг орж байна.

Зээлийн чанарын хувьд ногоон зээлийн 99% нь хэвийн ангилалд хамаарч байгаа бол ердөө 1% нь чанаргүй зээлийн ангилалд бүртгэгджээ.



“ЧИП төсөл”-ийн хүрээнд Монгол гэрийн халаалт, дулаалгын багцыг Улаанбаатар хот болон орон нутгийн салбаруудаар дамжуулан сарын 1.6%-ийн хөнгөлөлттэй хүүтэй зээлээр хэрэглэгчдэд санал болгож байна.

Тус төсөл нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн дэмжлэгээр зорилтот бүлгийн өрхүүдэд ЧИП багцыг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг бүрдүүлж буй.



Багцад хамрагдсан өрхийн амьдралд бодитой эерэг өөрчлөлтүүд гарч байна. Тухайлбал, гал түлэх шаардлагагүй болсноор:



Өрхийн гишүүдийн амьсгалын замын өвчлөл **75%-иар буурахад** нөлөөлж, эрүүл мэндийн байдал сайжирсан байна.



Өдөрт **30-90 минут**ыг хэмнэснээр гэр бүлтэйгээ илүү их цагийг өнгөрүүлэх, дасгал хөдөлгөөн хийх, шинэ зүйл сурах зэрэг эерэг дадлыг хэвшүүлэх боломжтой болсон юм.

Энэхүү төсөл нь эрүүл мэнд, байгаль орчин, нийгмийн хөгжлийн уялдаатай шийдэл бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

БАЙШИН ДУЛААЛГЫН “ДУЛААН ШИЙДЭЛ 2” ТӨСӨЛ



Европын Холбоо болон “Свич Эйшиа” хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Дулаан шийдэл 2” төсөл нь гэр хорооллын айл өрхүүдийн байшинг дулаалах, дулаан алдагдлыг бууруулах замаар агаарын бохирдлыг багасгах зорилготой юм.

Бид уг төслийн хүрээнд иргэдэд жилийн 6%-ийн хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөл бүхий ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож, байгаль орчинд ээлтэй байдлыг дэмжихийн зэрэгцээ тав тухтай амьдрахад санхүүгийн туслалцаа үзүүлж буй.

Энэхүү зээл нь гэр хороололд амьдарч буй иргэдийн амьдрах орчныг сайжруулах, эрчим хүчний үр ашигтай хэрэглээг дэмжих замаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодит үр дүнтэй нөлөө үзүүлэх чухал механизм болж байна.



Дээврийн дулаалга



Ханын дулаалга



Цонх дээвэр хосолсон багц



Хана, дээвэр, суурь хосолсон бүтэн дулаалга



Дашрамд дурдахад, тус төслийн хэрэгжүүлэгч байгууллага “Жэрэс” олон улсын төрийн бус байгууллагатай хамтран “Ногоон Технологи – 2024” арга хэмжээнд оролцож, иргэдэд ногоон зээл болон байгаль орчинд ээлтэй технологийн талаарх мэдээллийг амжилттай хүргэлээ.


Уг арга хэмжээ нь тогтвортой амьдралын хэв маягийг дэмжих, иргэдийн оролцоог идэвхжүүлэх, ногоон шийдлийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор зохион байгуулагдсан юм.




НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГА

В. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

GRI ESG ҮЗҮҮЛЭЛТҮҮД



МОНГОЛЫН БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН УДИРДАМЖ: НИЙГМИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн нийгмийн хариуцлага нь түр хугацааны нэг удаагийн үйлдэл бус, байгууллагын урт хугацааны хөгжлийн стратегийн салшгүй хэсэг юм. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэхэд санхүүгийн байгууллагуудын оролцоо, нөлөө улам бүр чухал болж байгаа энэ цаг үед Транскапитал ББСБ нь хариуцлагатай санхүүгийн байгууллагын жишгийг төлөвшүүлэн, олон талт санаачилга, үр дүнтэй үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн хариуцлагыг тогтвортой, тууштай хэрэгжүүлж байна.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ 7 ХОНОГ

Бид Монголбанктай хамтран “Дэлхийн мөнгөний долоо хоног – 2024” аяны хүрээнд хүүхэд, залуучуудад санхүүгийн суурь мэдлэг, зөв шийдвэр гаргах чадвар, хариуцлагатай хэрэглээний дадлыг төлөвшүүлэх зорилгоор идэвхтэй оролцлоо.

“Мөнгөө эрсдэлээс хамгаалж, ирээдүйгээ баталгаажуулья” уриан дор хэрэгжсэн энэхүү санаачилга нь байгууллагын нийгмийн хариуцлагын бодлоготой уялдсан бөгөөд санхүүгийн хүртээмжтэй боловсролыг дэмжих, тогтвортой хөгжлийг хангахад бодит хувь нэмэр оруулсан юм.



ХАНДИВ, ДЭМЖЛЭГ

Бид санхүүгийн амжилтыг зөвхөн тоон үзүүлэлтээр бус, нийгэмд бий болгож буй бодит үнэт зүйлээр хэмжих зарчмыг баримталдаг. Тиймээс ч өөрийн боломж, нөөц бололцоог үр дүнтэй ашиглан нийгэмд эерэг өөрчлөлт авчрах хандив, ивээн тэтгэлэг, сайн дурын санаачилгыг тогтвортой хэрэгжүүлж, хариуцлагатай санхүүгийн бодлого болон хүний төвтэй хөгжлийг дэмжихэд тууштай хувь нэмэр оруулсаар ирсэн билээ.



2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОЛ ХАНДИВ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД:



“АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ” сайн үйлсийн аян

Сүүлийн 6 жилийн турш тасралтгүй оролцож, цусны ховор бүлгийн донорын дэмжлэг үзүүлэв.



Малчдад туслах хандивын аян

Байгаль, цаг уурын эрсдэлд өртсөн малчдад туслах зорилгоор оролцож, хандивын дэмжлэг үзүүлэв.



Банк, санхүүгийн салбарын 100 жилийн ой

Монголын банк санхүүгийн бэлгэдэл болсон “Бухын хөшөө”-ний хандивын аянд оролцлоо.



“Хантайшир” бөхийн дэвжээг ивээн тэтгэх

Үндэсний спортыг дэмжих зорилгоор тогтмол ивээн тэтгэж байна.



Олон улсын тэмцээнд оролцсон тамирчдыг дэмжих

Монгол Улсаа төлөөлөн оролцсон тамирчдад ивээн тэтгэлэг үзүүлж, спортын салбарын амжилтад хувь нэмэр оруулав.



Энтрепренер арга хэмжээнүүд

Энтрепренер хөгжлийн төвөөр дамжуулан нийт 41 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 3439 иргэн, харилцагчийг үнэ төлбөргүй сургалт, семинар, уулзалт, нетворкинг үйл ажиллагаанд хамруулсан байна.



“Empowering Women 2024 Trade Tech Talent” арга хэмжээ

МҮХАҮТ-аас зохион байгуулсан жендерийн тэгш байдал, инновацийг дэмжсэн үйл ажиллагааг ивээн тэтгэлээ.



Монголын ББСБ-уудын холбооны хандивын аян

Салбарынхаа нийгмийн хариуцлагын үйл ажиллагааг дэмжиж, идэвхтэй оролцов.



Нэгдсэн сайн үйлсийн аянд 6 дахь жилдээ оролцов.

Санхүүгийн салбарын сайн дурын хамтын ажиллагааг тогтвортойгоор үргэлжлүүлж байна.

ТОГТВОРТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Тогтвортой хөдөлмөр эрхлэлт нь байгууллагын урт хугацааны өсөлт, хөгжлийн үндэс суурь бөгөөд ажилтан бүрийн сайн сайхан байдлыг хангахад чухал үүрэгтэй. Энэхүү зорилгын хүрээнд бид ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ тэдний санаачилга, оролцоог дэмжих урамшууллын стратегийг тогтмол хэрэгжүүлж байна.

Ажилтнуудын санал, гомдлыг нээлттэй, ил тод байдлаар хүлээн авч шуурхай шийдвэрлэх "Илт тод цонх" системийг хэрэгжүүлдэг



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэг журмыг чанд мөрдөж, хамт олны итгэлцэл, бүтээмжийг тасралтгүй сайжруулах бодлогыг хэрэгжүүлдэг

Ажил амьдралын уялдаа, эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж:

- Ажилтнуудын ажлын цагийг уян хатан зохицуулах;
- Зайнаас ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- Салбараас хол оршин суудаг ажилтнуудад унааны тэтгэмж олгох зэрэг бодит дэмжлэг үзүүлж байна.

Жендерийн тэгш байдлыг хангах, бүх ажилтанд хүртээмжтэй, оролцоотой ажлын орчин бүрдүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг

Эдгээр арга хэмжээнүүд нь тогтвортой, хариуцлагатай, хүртээмжтэй ажлын орчныг бүрдүүлэхэд чиглэн, байгууллагын нийгмийн хариуцлагын салшгүй, чухал бүрэлдэхүүн хэсэг болж амжилттай хэрэгжиж буй.



АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 онд байгууллагаас байгаль орчин, нийгмийн хариуцлагын систем (БОНУС) болон тогтвортой хөгжлийн чиглэлээр тасралтгүй сургалтуудыг зохион байгуулж, бүх ажилтнуудад улирал бүр тогтмол хүргэж ажиллалаа. Тодруулбал,



БОНУС СУРГАЛТ:

2024 оны IV улиралд Байгаль орчин, нийгмийн хариуцлагын систем (БОНУС)-ийн хэрэгжилт болон экологийн ул мөрийн талаарх тайлан, судалгааны үр дүнг нэгтгэсэн сургалтыг бүх ажилтнуудын дунд зохион байгууллаа.



ДОТООД БОЛОН ГАДААДЫН СУРГАЛТ:

2024 онд нийт ажилтнуудыг **2,438 хүн/цагийн** дотоод болон гадаад сургалтад хамруулсан бөгөөд энэ нь байгууллагын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулаад байна.

ТoC ХОЛБООНЫ ОНЛАЙН СУРГАЛТ:

Тогтвортой санхүүгийн холбооны онлайн сургалтад нийт **84** ажилтан хамрагдлаа.

Эдгээр сургалтууд нь ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, байгаль орчин болон нийгмийн хариуцлагын талаарх ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилготой бөгөөд байгууллагын тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд үе шаттайгаар өргөжүүлэн хэрэгжүүлж байна.

"ХЯЗГААРГҮЙ ҮНЭ ЦЭН - 2024"

2024 оны 8 сарын 17-нд "Хязгааргүй үнэ цэн" форумыг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү форумд Транскапитал ББСБ-ын Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 38 салбарын төлөөлөл оролцсон бөгөөд үүнээс орон нутгийн 20, нийслэлийн 18 салбарын ажилтнууд хамрагдсан юм. Арга хэмжээнээс онцлоход,

ФОРУМ 24

ХЯЗГААРГҮЙ ҮНЭ ЦЭН

- Энэ үеэр "Үнэ цэнийг түүчээлэгч" болон "Хэрхэн үнэ цэнийг бүтээлцэх вэ?" сэдвийн хүрээнд дотоод ажилтнууд болон харилцагчдын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулж, санал бодлоо солилцон, харилцан туршлага хуваалцлаа.
- Уг үйл ажиллагаа нь байгууллагын үнэт зүйлсийг онцлон таниулах, мөн ажилтнуудын хувь хүний болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой байв.





Ажилтны санал, гомдол хүлээн авах ба шийдвэрлэх үйл явц

Транскапитал ББСБ нь ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг албан ёсны имэйл хаяг болон бичгээр хүлээн авч, ил тод, хариуцлагатай байдлаар шийдвэрлэдэг тогтолцоотой.




Тайлант хугацаанд ажлын байрны бэлгийн дарамт болон бусад гомдлын тохиолдол бүртгэгдээгүй ба ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжих, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд тогтмол анхааран ажиллаж байна.

Хэрэв санал, гомдол бүртгэгдсэн тохиолдолд тухайн асуудлыг Гүйцэтгэх удирдлагад танилцуулж улмаар Хүний нөөцийн хэлтсээс ёс зүйтэй, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах үүрэг хүлээн ажилладаг.


ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

Ажилтнуудын хүйсийн харьцаа нь байгууллагын хүн хүчний бодлогын тэгш байдал, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд чухал үүрэгтэй.


Ажилтан




Менежер




Гүйцэтгэх удирдлага




ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Нийт ажилтнууд



Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнууд



■ Эрэгтэй
■ Эмэгтэй



ЭРХ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Манай байгууллага “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудыг дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг бөгөөд тэдэнд зориулан уян хатан ажлын цаг болон тохирсон ажлын орчин бүрдүүлэн ажилладаг.

Тодруулбал, хүний нөөцийн бодлогын хүрээнд бүх ажилтанд тэгш боломж, хамтын оролцоог хангах нь байгууллагын чухал үнэт зүйлсийн нэг ба хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд нийт ажилтнуудын 2.5%-ийг эзэлж байна.

Цаашид ч бид чадамжид суурилсан хандлагыг баримтлан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын ур чадвар, оролцоог дэмжих, тэдэнд амжилттай ажиллах таатай орчин бүрдүүлэх зорилтод бодлогоо тууштай хэрэгжүүлэн ажиллах болно.



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг чандлан мөрдөж, үүний дагуу ХАБЭА зөвлөлийг байгуулан холбогдох журам, дүрэм, стандартуудыг баталж, тогтмол хэрэгжүүлэн ажиллаж буй.

Тайлант хугацаанд ажлын байртай холбоотой ямар нэгэн осол, гэмтэл бүртгэгдээгүй ба энэ нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний бодит үр дүн юм.

Мөн ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах зорилгоор жил бүр ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын дундаж хугацаа 24 цаг байхаар төлөвлөж, тогтмол сургалтуудыг зохион байгуулсаар байна.

0

Ажлын байран дахь осол, гэмтлийн тоо

89.5%

Хөдөлмөрийн аюулгүй, таатай орчны талаар 2023 онд ажилтны сэтгэл ханамжийн судалгаа


10
удаа

Давтагдсан тоогоор ХАБЭА-н нийт сургалт



ШУДАРГА
ЗАСАГЛАЛ

С. ШУДАРГА ЗАСАГЛАЛ



ТОГТВОРТОЙ ЗАСАГЛАЛ


Манай байгууллага компанийн засаглалын бодлого болон дотоод дүрэм, журмаа Санхүүгийн зохицуулах хорооны баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлж байна.

Мөн байгууллагын бизнесийн ёс зүйн хэм хэмжээг нарийвчлан тодорхойлсон “Ёс зүйн кодекс”-ийг боловсруулан баталж, ажилтан бүр энэхүү кодексыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж буй.

Энэхүү кодекс нь байгууллагын эрхэм зорилго болон стратегийн зорилтод хүрэх үндэс суурь бөгөөд шударга, ил тод, хариуцлагатай үйл ажиллагааг бүх түвшинд хэрэгжүүлэх зарчмыг ажилтнуудад тууштай хэвшүүлэхийг зорьдог.



КОМПАНИЙН БҮТЭЦ



ТУЗ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХОРООД

Зээлийн хороо

Зээлийн хороо нь зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан компанийн зээлийн бодлого, стратегийн хэрэгжилтийг хангах, чиглүүлэх, зөвлөмж өгөх байдлаар дэмжлэг үзүүлдэг. Хороо нь хамтын ажиллагаа, зөв шийдвэр гаргалтын үндсэн дээр зээлийн багцыг тогтвортой хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь байгууллагын дотоод аудит, эрсдэлийн удирдлага, комплаенс болон санхүүгийн тайлагналын үйл ажиллагааг хянаж, шийдвэр гаргалтын үр нөлөөг дээшлүүлэх, хорооны тасралтгүй сайжруулалт, байгууллагын ил тод засаглалыг хангах үүрэгтэй. Улирал бүр зохион байгуулдаг хурлын үеэр менежмент, байгууллагын ёс зүй, хууль, дүрэм журмын хэрэгжилтийг шалгаж, хариуцлагын сахилгыг ханган ажиллаж байна.



Байгаль орчин, Нийгмийн хариуцлагын хороо

Байгаль орчин, Нийгмийн хариуцлагын хороо нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйл, алсын хараанд үндэслэн нийгэм, байгаль орчин, засаглалын тогтвортой хөгжлийн бодлогын стандартыг хэрэгжүүлэх, хянан хэрэгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогыг тодорхойлж, Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, чөлөөлөх зэрэг асуудлаар дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Тус хороо нь компанийн урт хугацааны хөгжлийг дэмжиж, тогтвортой удирдлагыг бэлтгэхэд анхааран ажиллаж байна.

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хороо нь удирдлагын баг болон эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан байгууллагын цалин, урамшууллын бодлогыг тодорхойлох үүрэгтэй. Хороо нь компанийн үнэт зүйл, зарчмыг баримталж, шударга, ил тод байдлыг ханган гүйцэтгэлийг урамшуулах замаар байгууллагын үр бүтээмжийг дээшлүүлэхийг зорин ажиллаж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Транскапитал ББСБ нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа Монгол Улсын болон олон улсын холбогдох хууль, стандартуудыг чанд мөрдөн хэрэгжүүлдэг. Манай компанийн эрсдэлийн удирдлагын бүтэц нь гурван шугамт хамгаалалтын загвараар зохион байгуулагдсан бөгөөд компанийн бүх түвшинд эрсдэлийг бууруулах, хэмжих зорилгоор хэлтэс хоорондын нягт хамтын ажиллагаа, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэн хөгжүүлж байна.

Эрсдэлийг ил тод үнэлэхэд Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг дотоод болон гадаад аудитын байгууллагууд дэмжиж ажиллахаас гадна, бүх үйл ажиллагаандаа дотоод хяналтын процессыг хэрэгжүүлж байгаа нь өдөр тутмын үйл ажиллагаа болон санхүүгийн эрсдэлийн удирдлагад эерэг нөлөө үзүүлж байна.

Комплаенс

- Транскапитал ББСБ нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудын журам, заавар, мөн ФАТФ-ын зөвлөмж, олон улсын холбогдох байгууллагуудын шаардлагыг чанд мөрдөж, дотоод бодлого, журмуудаа нийцүүлэн боловсруулж, комплаенс болон ёс зүйг эрхэмлэн ажилладаг.

Компанийн засаглалын кодексийн дагуу 2023 оноос эхлэн жил бүр засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад илгээж, тайлангийн

хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах ажлын хүрээнд бодлого, журам боловсруулан хэрэгжүүлж байна.

Үүний хүрээнд 2024 онд Компаенсын хяналтын хөтөлбөрийг шинэчилж боловсруулан амжилттай хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг хөтөлбөрийн дагуу бүх түвшний ажилтны компаенсын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсноор компаенсын үйл ажиллагаа илүү үр дүнтэй, системтэй шатанд шилжсэн.

Компаенсын ерөнхий үйл ажиллагаанаас гадна байгууллагын газар, хэлтсийн төлөөлөлтэйгээр бүрдсэн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж ажиллаж байна. Тус нэгж нь МУБТСҮОХЗДБТТ хөтөлбөрийг шинэчлэх, ажилтнуудад сургалт, зөвлөмж хүргэх, сэжигтэй гүйлгээг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй бөгөөд Гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Цаашлаад, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын бүх түвшний ажилтнуудад тогтмол сургалт, мэдээлэл хүргэж буй.

Мөн 2024 онд БОНУС хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт 94.5% байснаар байгууллагын



тогтвортой хөгжлийн зорилтууд амжилттай хэрэгжиж байгааг харуулж байна.

Эрсдэлийн удирдлагын хүрээнд өндөр эрсдэлтэй буюу засварлах шаардлагатай зээл бүртгэгдээгүй бөгөөд энэ нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байгаагийн илрэл юм.

Авлига, ёс зүй

2024 онд шударга ёс, ёс зүйг эрхэмлэсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх, бүх түвшинд түгээн нэвтрүүлэхэд анхааран ажиллалаа. Энэ хүрээнд нийт ажилтнуудад зориулсан “Байгууллагын давуу тал – Ёс зүй, хандлага” сэдэвт сургалт болон авлига, хээл хахууль, залилангийн эсрэг журмын хэрэгжилтийг хангах чиглэлийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Мөн компанийн Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, “Ажилтны эрхэмлэх зүйлс” нэрийн дор дараах үнэт зарчмуудыг албан ёсоор баталгаажуулсан нь байгууллагын ёс зүйн тогтолцоог бэхжүүлэх, тогтвортой хэрэгжилтийг хангахад чиглэсэн чухал алхам болсон юм. Үүнд:

- Харилцагч хамт олондоо хүндэтгэлтэй байх
- Шударга ёсыг сахих
- Мэргэжлийн ёс зүйтэй, хариуцлагатай байх
- Аюулгүй орчин, эрүүл ахуйг эрхэмлэх
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
- Авлига, хээл хахууль, залиланг үл тэвчих
- Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

Эдгээр зарчмууд нь хууль, ёс зүйн нийцэлд суурилсан засаглалын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн бөгөөд



байгууллагын бүх түвшинд бодитоор хэрэгжиж буй сургалт, танилцуулга болон хяналт, үнэлгээний шалгалтын үр дүн харуулж байна.

Тайлант хугацаанд авлига, ёс зүйн зөрчил болон ашиг сонирхлын зөрчил бүртгэгдээгүй нь байгууллагын ёс зүйн өндөр стандарт, урьдчилан сэргийлэх тогтолцоо үр дүнтэй ажиллаж байгааг илэрхийлж буй.



Харилцагчийн эрхийг хамгаалах

“Санхүүгийн салбарын харилцагчийн эрхийг хамгаалах” олон улсын форумд 13 улсын бодлого боловсруулагчидтай хамтран оролцож, тогтвортой, хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээний талаар өрнөсөн хэлэлцүүлэгт амжилттай оролцсон нь Транскапитал ББСБ-ын олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх, хариуцлагатай санхүүгийн тогтолцоог төлөвшүүлэхэд чиглэсэн бодит алхмын нэг боллоо.



“Харилцагчийг хамгаалах бодлогын баримт бичиг боловсруулах” үйл ажиллагааны хүрээнд Монголын ББСБ-уудын холбооны дэргэд байгуулагдсан ажлын хэсэгт идэвхтэй оролцож, “Хариуцлагатай санхүүгийн жил” зорилгыг дэмжихийн зэрэгцээ гадаад эх үүсвэрийн санхүүжилт татах үйл ажиллагаанд зөвлөх хэлбэрээр дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Энэхүү оролцоо нь:

- Харилцагчийн эрх, ашиг сонирхлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хамгаалахад бодитой хувь нэмэр оруулсан;
- Санхүүгийн салбарын бодлого, чиг хандлагын хэлэлцүүлэгт Монгол Улсыг төлөөлөн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран оролцсон стратегийн ач холбогдол бүхий оролцоо болсон;
- Хариуцлагатай санхүүжилтийн үзэл баримтлал, туршлагыг олон улсын түвшинд хуваалцах боломжийг бүрдүүлсэн.



Бид үйл ажиллагаандаа харилцагчийн эрхийг хамгаалах дараах 8 стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.



Тайлант хугацаанд харилцагчаас ирсэн санал хүсэлт, гомдлын хариуг ажлын 8 цагийн дотор хариу тайлбар болон гомдол хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэгдэж ажилласан байна.



3 БҮЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ БОЛОН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ



ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛӨЛ БОЛОН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ

Транскапитал ББСБ нь нийгэм, байгаль орчин, эдийн засгийн уялдаа холбоог гүнзгий ойлгон, хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулахыг эрхэм зорилгоо болгон ажилладаг.

Бид харилцагчийн байгаль орчин болон нийгмийн эрсдэлийг үнэлэн, өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанаас ангид байх бодлого баримтлан, эрүүл, тогтвортой эдийн засгийн бүтцийг дэмжихийг зорьдог.

Мөн эдийн засгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийгмийн санхүүгийн нөлөөллийг онцгойлон анхаарч, Олон улсын болон дотоодын дараах хөтөлбөр, санаачилгуудыг “Энтрепренер хөгжлийн төв (EDC)”-өөр дамжуулан хэрэгжүүлж байна.



ТӨВ АЗИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР



ЗАЛУУ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



European Bank
for Reconstruction and Development

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ
ХӨГЖЛИЙН БАНКНЫ GEFF НОГООН
САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР

Эдгээр хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт олгохоос гадна бид харилцагчийн эдийн засгийн хөгжил, идэвхтэй оролцоог дэмжих замаар хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийг бий болгоход манлайлан оролцож байна.

Санхүүгийн хүртээмж

■ **Энтрепренер Хөгжлийн Төв (EDC): БЖДБ-ийг дараагийн түвшинд гаргах гүүр**

Транскапитал ББСБ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, өсөлт хөгжлийг дэмжих зорилгоор “Энтрепренер Хөгжлийн Төв (EDC)”-ийг байгуулан амжилттай ажиллуулж байна. Энэхүү төв нь БЖДБ болон хувиараа бизнес эрхлэгчдэд санхүү, мэдлэг мэдээллийн цогц дэмжлэг үзүүлдэг.

Хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй, уян хатан нөхцөлтэй зээлийг санал болгож, зээл авах боломж хязгаарлагдмал байсан эмэгтэй болон залуу бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллаж буй. Мөн Монгол орны өнцөг булан бүрт хүрч, санхүү, нягтлан бодох бүртгэл, маркетинг, хувь хүний хөгжил зэрэг чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.

2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ
АЖИЛЛАГАА:





Бид “Энтрепренер Хөгжлийн Төв”-ийнхөө үйл ажиллагааг шат дараатайгаар өргөжүүлж, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон залуучуудыг дараагийн түвшинд хөгжүүлэх, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тус төвөөр дамжуулан хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийн хүрээнд нийт 41 удаагийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, 3,439 иргэн, харилцагчийг хамруулаад буй. Үүнээс Улаанбаатар хотод 7 удаагийн, харин 18 аймагт (давхардсан тоогоор) нийт 34 удаагийн сургалт, бизнес уулзалт, эвент болон бусад үйл ажиллагаа зохион байгуулагдсан нь бодит үр дүнтэй хэрэгжилтийн нэгээхэн илрэл юм.

Ийнхүү бидний хязгааргүй үнэ цэнийг бүтээх, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх үйслс тасралтгүй үргэлжлүүлсээр байна.



34
сургалт, бизнес
уулзалт, эвент

3439
иргэд
харилцагч

41
удаа үйл
ажиллагаа

Нийт хамрагдсан иргэн, харилцагчдын 85%-ийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд тэдний 40%-ийг 35 наснаас доош насны эмэгтэй бизнес эрхлэгчид бүрдүүлж буй.

харилцагчдын
85%
эмэгтэйчүүд



35
наснаас доош



40%

ХАРИЛЦАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ



ЖБД-ИЙН
ЗЭЭЛИЙН
БАГЦ

64%



БИЗНЕС ЭРХЛЭГЧ
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ЗЭЭЛ

54%

нийт бизнесийн
зээлэнд эзлэх хувь



ЭМЭГТЭЙ
ХАРИЛЦАГЧ

50%



ЗАЛУУ БИЗНЕС
ЭРХЛЭГЧ

36%

35-аас доош нас

Манай нийт зээлийн багцын 61%-ийг бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд олгосон зээл бүрдүүлж байгаа бөгөөд 2024 онд нийт 14,400 ажлын байранд шууд нөлөө үзүүлэн ажилласан байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсад бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй бичил, жижиг, дунд болон бусад байгууллагуудын (БЖДБ) хөгжлийг дэмжихэд санхүүжүүлэгч байгууллагуудын стратегийн түншлэл чухал үүрэгтэй.

Транскапитал ББСБ нь энэ чиглэлд олон улсын нэр хүндтэй байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, 2024 онд Европын Сэргээн Босголт ба Хөгжлийн Банк (ЕСБХБ), Incofin, Symbiotics, WaterEquity, MCE Social Capital зэрэг санхүүжүүлэгчидтэй хамтран хэд хэдэн төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ.

Эдгээр хамтын ажиллагааны хүрээнд зорилтот санхүүжилт болон санхүүгийн бус үйлчилгээгээр дамжуулан бизнес эрхлэгч эмэгтэйчүүд болон залуучуудын чадавхыг нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдийг баталгаат ундны усаар хангах, хөрсний бохирдлыг бууруулах зэрэг нийгэм, байгаль орчны чухал асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулсан юм.

Эцэст нь, Транскапитал ББСБ-ийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжихээс гадна тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагыг бодитоор хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол, урт хугацааны эерэг нөлөө үзүүлсээр байгааг онцлон тэмдэглэхэд таатай байна.

Тогтвортой хөгжил, байгаль орчны чиглэлээр ОУ-ын болон дотоодын холбоо нэгдэлтэй хамтран ажилласан байдал



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монголын компаниудад зориулсан БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамжийн дагуу ашигласан үзүүлэлтүүд



ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН
УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦООНЫ
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

MS1. Удирдлагын амлалт	MS1.1 Танай компанийн удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн асуудлаар авсан амлалт/ хийсэн мэдэгдэл бий юу?
MS2. Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги ба журам	MS2.1 Танай компани тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа баталсан уу?
	MS2.2 Танай компани тогтвортой хөгжлийн талаар баримтлах дүрэм, журам бий юу?
MS4. Тогтвортой байдлын материаллаг байдлын үнэлгээ	MS4.1 Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, улмаар эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх талаар хийсэн материаллаг байдлын процесс, үнэлгээ, матриц танай компанид бий юу?
MS5. Чадавх бүрдүүлэлт	MS5.1 Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн асуудлаарх сургалтад жилд зарцуулсан дундаж хугацаа (цаг), хүйсээр
MS6. Хяналт шинжилгээ	MS6.1 Аудитын хороо (эсвэл ижил төстэй удирдах зөвлөлийн хороо)-ны хийх ажлын хүрээ, дотоод хяналтын чиг үүрэгт тогтвортой хөгжлийн асуудал хамаардаг уу?
MS7. Тогтвортой байдлын тайлагнал	MS7.1 Танай компани тогтвортой байдлын тайланг (тусгайлан/буюу жилийн тайланд нэгтгэж) хамгийн багадаа жилд нэг удаа гаргадаг уу?
	MS7.2 Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх олон улсын стандарт (YAӨСMTAX & БОТСMTAX)-ын дагуу тайлагнадаг уу?
	MS7.3 Тогтвортой байдлын талаарх мэдээлэлдээ хараат бус гуравдагч этгээдээр баталгаа гаргуулдаг уу?
MS8. Гишүүнчлэл	MS8.1 Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг (бизнес, хүний эрх гэх мэт) олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?





БАЙГАЛЬ
ОРЧНЫ
ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

 	E1. Эрчим хүч	E1.1 Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ (кВтц) болон зардал (төг) E1.2 Цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээ(кВтц), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар) E1.3 Дулааны эрчим хүчний нийт хэрэглээ (Гкал, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар) E1.4 Түлшний нийт хэрэглээ (нүүрс, газрын тос, байгалийн хий гэх мэт) (Литр, Гдж), зардал (төг), хэмнэлт (өмнөх жилийн мөн үетэй харьцуулснаар)
	E2. Хүлэмжийн хийн ялгарал	E2.1 Компанийн шууд (Scope 1) болон шууд бус (Scope 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн нийт ялгарал (метр тонн CO2-экв) E2.2 Компанийн шууд (Scope 1) болон шууд бус (Scope 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт (метр тонн CO2-экв) E2.3 Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний үр дүнд бууруулсан нүүрсхүчлийн хийн ялгаруулалт (метр тонн CO2-экв) Нэмэлт үзүүлэлтүүд: - Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилт, - Компанийн шууд (Хамрах хүрээ 1) болон шууд бус (Хамрах хүрээ 2) үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал (метр тонн CO2-экв), эх үүсвэрийн төрлөөр,
	E3. Уур амьсгалын өөрчлөлт	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн бодлого бий юу? Танай компани уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдэл болон боломжийн талаар үнэлгээ (олон хувилбартай дүн шинжилгээ, стресс тест гэх мэт) хийсэн үү? Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, онцгой тохиолдлуудын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ (төг) Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн дэд бүтэц, дасан зохицох, бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд жилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн (төг) Танай компани уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?

НИЙГМИЙН
ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

S1. Хүний нөөц	Нэг ажилтанд ногдох сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)
S1. Нэмэлт	Албан тушаал дэвшсэн ажилтнуудын тоо, хүйсээр
	Ажилтнуудын дунд жил бүр явуулдаг сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хүйсээр
	Ялгаварлан гадуурхлын тохиолдлын тоо, хүйсээр
	Хүүхдийн хөдөлмөрийн тохиолдлын тоо
S2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Танай компанид ХАБЭА-н бодлого, журам (тусгайлсан эсвэл бусад журамд нэгтгэсэн) бий юу?
	Ажил үүрэгтэй холбоотойгоор жилд гарсан осол гэмтлийн тохиолдол, хувиар (%)
	Нэг ажилтанд ногдох ХАБЭА-н сургалтын жилийн дундаж хугацаа (цаг)
S3. Эрх тэгш байдал	Танай компанид Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?
	Танай компанид Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?
	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын эзлэх хувийн жин (%)
	Гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин (%)
	Дунд болон анхан шатны нэгж дэх эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын хувийн жин (%)
	Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа
S4. Хүртээмжтэй байдал	Та компанид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?
	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь (%)
S5. Нийгмийн хариуцлага, олон нийтийн оролцоо	Танай компанид гомдол маргаан шийдвэрлэх бодлого, механизм бий юу? (Тийм/Үгүй)
	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? (Тийм/Үгүй)
	Олон нийтээс хүлээн авч i) шийдвэрлэж байгаа ii) шийдвэрлэсэн санал гомдлын хувь (%)
	Олон нийтэд чиглэсэн нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрүүдэд зарцуулсан зардлын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-ын ангиллаар (%)
S6. Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээний удирдлага	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь (%)
	Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ)-үүдтэй хийсэн худалдан авалтын төсөв, хувиар (%)





ЗАСАГЛАЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	G1. Компанийн засаглал, Удирдах зөвлөл	Танай компани шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, тайлагнал хийдэг үү?
		Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн хувийн жин (%)
		Танай компанид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах дүрэм, журам бий юу?
	G2. Авлига, ёс зүй	Танай компанид авлигын эсрэг бодлого болон/буюу ёс зүйн дүрэм, журам бий юу?
	Нэмэлт үзүүлэлтүүд	Энэ он болон өмнөх онуудад холбогдох авлигын гэмт хэргийн нийт тоо, шинж чанар.
		Ёс зүйн болон авлигатай тэмцэх тухай сургалтад хамрагдсан ажилтнуудын хувийн жин (%)
Авлигатай холбоотой эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагаа (%)		
G3. Комплаенс	Танай компанид комплаенсын бодлого, журам бий юу?	
	Танай компанид комплаенсын хөтөлбөр (ажилтнуудад зориулсан сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн тухай мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хориг тавих зэрэг асуудлаарх заавар, журам гэх мэт) бий юу?	
САЛБАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД	FS. Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцогчдын тоо, жилээр
		Нийт зээлийн багцад Монгол Улсын ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээл, санхүүжилтийн эзлэх хувийн жин (%)

Материаллаг байдлын үнэлгээ

Байгаль орчин


- Эрчим хүчний хэмнэлт
- Тогтвортой хэрэглээ

Нийгмийн хариуцлага

- Job creation
- Ажилтнуудын сургалт, хөгжил
- Хэрэглэгчидийн сэтгэл ханамж
- Санхүүгийн оролцоо, literacy

Засаглал

- Мэдээллийн аюулгүй байдал
- Комплаенс
- Ёс зүй
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоо
- Ил тод байдал

Тантай хамт 
Аз жаргалын төлөө